

Хэлсэндээ хүрэх ёс суртахуун Идэвхитэй оролцооны ёс зүй



Бяцхан Хаан Жей Си Ай
Монгол хувилбар

Mongolische Erstausgabe

Titel: Хэлэндээ хүрэх ёс суртахуун

Идэвхитэй оролцооны ёс зүй

© 2018 Friedhelm Wachs

Umschlag/Illustration: strichfiguren.de (Adobe Stock)

Autor: Friedhelm Wachs

Übersetzung: Nara Namshir

Lektorat, Korrektorat: Sabine Schierwagen

Die deutsche Originalausgabe erschien 2018 im

Verlag: Metropolis Medien Verlags GmbH, Leipzig

ISBN: 978-3-7479-0085-7

Das Werk, einschließlich seiner Teile, ist urheberrechtlich geschützt. Jede Verwertung ist ohne Zustimmung des Verlages und des Autors unzulässig. Dies gilt insbesondere für die elektronische oder sonstige Vervielfältigung, Übersetzung, Verbreitung und öffentliche Zugänglichmachung.

Bibliografische Information der Deutschen Nationalbibliothek:

Die Deutsche Nationalbibliothek verzeichnet diese Publikation in der Deutschen Nationalbibliografie; detaillierte bibliografische Daten sind im Internet über <http://dnb.d-nb.de> abrufbar.

www.littlekingjci.com

Энэхүү бяцхан түүхийг маань дэлхийн аль болох олон хэл рүү хөрвүүлэхэд та туслаарай. Энэхүү бичвэрийг өөрийн хэл рүү орчуулна уу.

by Friedhelm Wachs || Senator #62758
European Senate President 2018/2019

орчуулагч: Nara Namshir
хэл: Mongolian (Монгол)

**Эрт урьдын цагт нэгэн бяцхан хаан байжээ.
Түүний нэрийг Анхдугаар иргэн Жей (Жей Си
Ай) гэдэг байжээ. Жей Си Ай бүхэл өдрийн
турш гунигтай байлаа.**





Учир нь түүний эргэн тойронд бүгд хувиа хичээж байгааг олж харлаа. Хэн ч бусад хүмүүстээ анхаарал тавьж, халамжлахгүй. Бяцхан саарал хаад зөвхөн өөрсдийгөө л бодож, харин том саарал хаад тэднээс бүр ч дор байлаа. Гэсэн хэдий ч тэдний хэн нь ч аз жаргалтай байсангүй.

Юу болох нь энэ вэ?

Бяцхан хаан Жи Си Ай энэ байдлыг өөрчлөхийг хүслээ. Тэр бусад хүмүүст зориулж ямар нэгэн зүйл хийхийг хүсэв. Ялангуяа хүүхдүүдэд, бизнест, боловсролд, ядууст болон хөршүүддээ зориулж илүү ихийг хийхийг хүсч байв.

Тэрээр мөн инээхийг хүсч байв. Илүү хөгжилтэй, аз жаргалтай амьдарч, энэ гайхамшигт ертөнцийг танин мэдэж, шинэ нээлт хийж, суралцахыг хүсч байлаа. Гэвч бяцхан хаан ганцаараа яаж энэ бүхнийг хийх билээ.

Тэр бодоод л байж.. бодоод л байж ... гэтэл гэнэт нэгэн санаа төрлөө.





**Яагаад би амьдралдаа өөрчлөлт хийхийг
хүссэн бусад хаадтай ярилцаж болохгүй гэж”
хэмээн боджээ.**

**“Бусдаас суралцана гэдэг бол амжилтын үндэс
гэж” Жей Си Ай итгэлтэйгээр үргэлжлүүлэн
бодлоо.**

**Ийнхүү тэрээр бусад хаадтайгаа уулзахаар урт
удаан аялалд гарлаа.**

Хөх хатан ийнхүү өгүүлэв:

Агуу хүмүүс “улс орон миний төлөө юу хийж чадахыг биш харин би өөрөө улс эх орныхоо төлөө юу хийж чадах вэ?” гэж асуудаг. Энэ бол жинхэнэ харилцан хүндлэл юм. Ингэж чадвал чи аз жаргалтай болно.





**Энэ бол гайхалтай зөвлөгөө байлаа. Дэгдэн
дэгдэн алхсаар бяцхан Хаан Жей Си Ай аяллаа
үргэлжлүүлээ.**





Ногоон хааны хэлснээр:

Жижиг чулуунуудыг зөөж эхэлсэн хүн
уулыг нүүлгэж чаддаг. Хэрвээ бид
хамгийн эхний алхмыг хийж чадвал
түүнээс том даалгаварын ард гарч чадна
гэсэн үг. Энх тайванг тогтоож болно гэдэг
НҮБ-ын зорилтыг бид биелүүлж чадна.



**“Ямар гайхалтай юм бэ” гэж бяцхан хаан
Жей Си Ай бодов. Зөвхөн эхлүүлэх нь эерэг
өөрчлөлтөнд хүрэх түлхүүр юм гээд аяллаа
үргэлжлүүлэв.**



Улаан хаан түүнд ийнхүү зөвлөв:



Зах дээр загасыг биш загасны уургыг зар. Хэрэв хүмүүс загас барьж сурвал өөрсдөдөө тусалж сурна. Өөрөө өөртөө туслана гэдэг бол бидний үүрэг. Энэ бол эрх чөлөө. Эрх чөлөөтэй хүмүүс шударга ёсыг хамгаалж чаддаг.





“Гайхалтай” гэж Жей Си Ай бодлоо. Их хэрэгтэй юм гэж нүүрэндээ инээмсэглэл тодруулсаар цааш явлаа.




Нил ягаан хатан түүнд хэлжээ:



Хүний хамгийн нандин зүйл бол материаллаг эд зүйлс биш юм. Харин хамгийн нандин зүйл бол түүний үзэл бодол болон хувь чанар юм. Үзэл бодлоо зөв чиглүүлэх тусам чи нийгэмд илүү сайнаар үйлчилж чадна.

“Амьдралынхаа туршид үзэл бодлоо чиглүүлэн, сургах. Таатай сонсогдож байна. Ингэснээр бид эргэн тойрондоо, бусаддаа тулгарч буй хүндрэлүүдийн талаар илүү ойлголттой байх болно гэж Жей Си Ай бодов.

Бяцхан хаан аяллаа цааш үргэлжлүүлсээр...



Цэнхэр хаан үүнийг мэдэж байжээ:



Агуу хүн бол ялгаварлан гадуурхахгүйгээр,
хэн нэгэнт давуу тал олголгүй эрх тэгш
удирддаг. Манлайлал бол хүн бүрт
ижил тэгш зарчим тогтоож чадсан үед
хүлээн зөвшөөрөгдөнө. Ямар ч харилцаа,
нөхөрлөл үүнийг эвдэж чадахгүй, гагцхүү
хууль дүрэм л үйлчилнэ.



Зөвхөн найз нөхдийг илүүд үзэхгүй байх нь хамтын амьдралыг илүү аз жаргалтай болгодог. Хүн бүрт эрх тэгш дэг журам. Энэ бол маш сайхан санаа. Энэ санаагаа өөртөө өвөрлөөд Жей Си Ай цаашаа аялсаар...



Улбар шар хаан хүүрнэхдээ:

Чи хаашаа ч зорьсон бай бүхий л сэтгэл зүрхээ зориулж бай. Аливаа зүйлийг өөрийн санаачлагаар, чин сэтгэлээсээ хийсэн цагт үйлдэл чинь үнэ цэнэтэй болдог гэдгийг санаарай.





**Гэнэт бяцхан хаан Жей Си Ай дээшээ хартал
тэртээ хол нэгэн цайзыг харав. Тэр аль хэдийн
гэртээ ирсэн гэж үү.**

**Тэр аз жаргалтайгаар, бас хялбарханаар
дэлхийг тойрч, олон сайхан зөвөлгөөнүүд
сонсжээ.**

Жей Си Ай хаад, хатдын зөвлөж хэлсэн
бүхнийг амьдралдаа хурдхан хэрэгжүүлж
эхлэв.

Тэрээр өөртэй нь адил энэ бүгдийг ойлгож
мэдээсэй гэж хүсч, ард иргэдээ аялуулав.

Тэд дэлхий дээр сайн зүйлсийг хийж, бас
хөгжилтэй сайхан байх ёстой. Тэд бусдад үүдээ
нээж, бие биеэ элгэмсгээр угтан авч байлаа.
Зочид нь ч мөн дагаж мөрдөж дэг журмыг
бий болголоо.


Энэ бүхэн хөгжилтэй байлаа.





Бусад хаад бяцхан хаан Жей Си Ай-аас маш их зүйл сурснаа ойлгов. Жей Си Ай сурсан мэдсэн бүхнээ бусаддаа түгээж, өөртөө юу ч авч үлдээгүй учраас тэд их аз жаргалтай байлаа. Тэрээр бусад хаадтай үнэтэй зөвөлгөөгөө сэтгэл харамгүй хуваалцжээ. Тэд өдөр бүр бага багаар дэлхийг илүү сайхан болгож байлаа.

Нэгэн өдөр бүх хаад дахин уулзав. Тэд өдөржин шөнөжин цэнгэлдэж, нэг нэгнээсээ суралцаж, бас бие биенийхээ тухай илүү ихийг мэдэж авчээ. Тэд өөрсддөө нэр өгөв. Тэд бяцхан хаан Жей Си Ай – ийн нэрээр өөрсдийгөө Жейсийс гэж нэрлэв.







Уулзалт гайхалтай сайхан
болсон учраас тэд багадаа
жилд хоёр удаа чуулган
зохион байгуулахаар
болов.

Тэд дэлхийн чуулган,
бүсийн чуулган, үндэсний
чуулган тэр байтугай орон
нутагтаа чуулган зохион
байгуулж, туршлага
солилцох боломжуудыг
бүрдүүлжээ.

Эцэст нь тэд том, муухай хувиа хичээгчдээс
илүү давуу талтай болжээ.

Жейсийчүүд илүү аз жаргалтай болсон. Тэд
илүү шударга болсон. Тэд өөрсдийн улс орныг
илүү өнгөлөг болгож, хамтдаа инээмсэглэж
байна.







Үүнээс чин сэтгэлийн идэвхитэй оролцооны ёс
зүй гарч ирэв.
Хаан бүр өөрсдийн бодлыг бичээд хамтдаа тэд
тунхагаа бий болгожээ.

БИД ИТГЭДЭГ:

- Итгэл үнэмшил хүний амьдралыг утга учир, зорилготой болгоно гэдэгт
- Ахан дүүсийн барилдлага улс үндэстний хилийг даван гарна гэдэгт
- Эрх чөлөөт хүмүүс эдийн засгийн шударга ёсыг тогтооно гэдэгт
- Хувь хүнээр бус хуулиар зохицуулагддаг засаг төртэй байна гэдэгт
- Энэ ертөнцийн эрхэм баялаг хүний мөн чанарт оршино гэдэгт
- Хүн төрөлхтөний төлөө зүтгэх нь амьдралын хамгийн чухал үйлс мөн гэдэгт





Бид Жей Си Ай-ийн хүч чадлыг харуулахыг хүсч байна. Бид бол дэлхийн хаанаас ч олдохгүй нэгдэл бас ялгарал. Бид бүгд өөрийн улсын албан ёсны хэлээр ярихаас гадна эх хэл, эцэг хэл, бүс нутгийн хэл болон овог аймгийн хэлээр ярьдаг.

Хамтдаа үүнийг үзүүлье.

Энэхүү бяцхан түүхийг маань дэлхийн аль болох олон хэл рүү хөрвүүлэхэд та туслаарай. Энэхүү бичвэрийг өөрийн хэл рүү орчуулна уу.

Орчуулгаа доорх хаяг руу илгээгээрэй:
book@littlekingjci.com



www.littlekingjci.com



ISBN: 978-3-7479-0085-7